Тус газар нь үйл ажиллагааны зорилгоо “Нийслэлийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэж, идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, нийслэлд биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах, спортын барилга байгууламжийг зориулалтаар нь ашиглахад анхаарч, тэдгээрийг түшиглэн биеийн тамир, спортын төвлөрсөн арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Биеийн тамир, спортын тухай хууль;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ТБОНӨХБАҮХАТХ хууль шинэчлэн найруулсан
- ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай”;
- ЗГ-ын 2024 оны 2 дугаар тогтоол “Худалдан авах ажиллагаанд төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ



илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа боловч Сангийн сайдын тушаалаар батлагдсан журам өөрчлөгдсөнтэй холбоотой системийн хэмжээнд 2025 онд бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49,882.5 мянган төгрөгөөр буюу 21.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл   | /мянган төгрөгөөр/ |                 |
|----------------------------------------------|------------------|--------------------|-----------------|
|                                              |                  | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт        |
| Б                                            | 1                | 2                  | 3=2-1           |
| Мөнгөн хөрөнгө                               | 1,474.8          | 0.00               | (1,474.8)       |
| Бараа материал                               | 20,610.0         | 21,931.3           | 1,321.3         |
| Үндсэн хөрөнгө                               | 215,224.3        | 265,260.3          | 50,036.0        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>237,309.1</b> | <b>287,191.6</b>   | <b>49,882.5</b> |
| Өр төлбөр                                    | 4,274.9          | 1,200.00           | (3,074.9)       |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 233,034.2        | 285,991.6          | 52,957.4        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>237,309.1</b> | <b>287,191.6</b>   | <b>49,882.5</b> |

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, эздийн өмч данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,474.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ажил үйлчилгээний барьцаа төлбөрийн үлдэгдлийг тайлант онд төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 21,931.3 мянган төгрөг болж 1,321.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд зохион байгуулагдсан тэмцээн, уралдаанд зориулж техник хэрэгсэл худалдан авсан холбоотой байна.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 265,260.3 мянган төгрөг болж 50,036.0 мянган төгрөгөөр өссөн нь НӨХГ-ын шийдвэрээр 11,778.5 мянган төгрөг, НЗДТГ-ын шийдвэрээр 54,947.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн тоног төхөөрөмжийн өсөлт болон тайлант онд 19,090.30 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,200.0 төгрөг болж 3,074.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулсантай холбоотой байна. Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 285,991.6 мянган төгрөг болж 52,957.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 578,264.10 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 75,150.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 656,334.4 мянган төгрөгөөр баталжээ. Энэ нь цалин хөлсний зардлыг 55,940.3 мянган төгрөг, ажил олгогчоос олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардлыг 6,992.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 1,857.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 11,900.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 19,011.7 мянган төгрөгөөр тус тус бууруулж, эд хогшил худалдан авах зардлыг 3,380.3 мянган төгрөг, урсгал санхүүжилт 28,548.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 137,943.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс, тайлант онд зохион байгуулагдах олон улсын тэмцээн уралдааны зардлыг дутуу тооцсоноос шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 656,334.4 мянган төгрөгийг улсын төсвийн орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 656,334.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаандаа 645,828.7 мянган төгрөг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 10,505.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, зориулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

|   | Хөтөлбөр, зориулалт                   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | /мянган төгрөгөөр/ |         |
|---|---------------------------------------|------------|-----------|--------------------|---------|
|   |                                       |            |           | Зөрүү              | Биелэлт |
| 1 | 71701-Биеийн тамир, спорт             | 656,334.4  | 645,828.7 | 10,505.6           | 98.4    |
| 2 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал   | 453,712.1  | 443,210.5 | 10,501.6           | 97.7    |
| 3 | 80802- Ажил олгогчоос олгосон тэтгэмж | 57,622.3   | 57,622.3  | 0.0                | 0.0     |



|   |                                        |          |          |      |      |
|---|----------------------------------------|----------|----------|------|------|
| 4 | 80305- Биеийн тамирын уралдаан тэмцээн | 85,000.0 | 85,000   | 0.00 | 100  |
| 5 | 82106- Нийтийн биеийн тамир            | 60,000.0 | 59,995.6 | 4.35 | 99.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд НЗДТГ-ын гүйцэтгэлийн санхүүжилтээр 2,020,767.8 мянган төгрөг, Нийслэлийн Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газраас 11,745.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 191,329.1 мянган төгрөг, Биеийн тамир спортын улсын хорооноос 8,000.0 мянган төгрөг, нийт 2,231,841.9 мянган төгрөгийн орлого олж, 2,199,571.3 мянган төгрөгийг зарцуулж, 32,270.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Зарцуулалтыг дэлгэрэнгүй харуулахад:

- Спортын мэргэжлийн төрийн бус байгууллагуудад 1,090,145.0 мянган төгрөг;
- Бараа материалын зардалд 311,693.6 мянган төгрөг;
- Тэмцээн уралдаан зохион байгуулах зардалд 504,592.5 мянган төгрөг;
- Уралдааны тэмцээний шагнал, урамшуулалд 64,209.5 мянган төгрөг;
- Түрээс, талбайн зардалд 130,051.4 мянган төгрөг;
- Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны зардалд 81,121.3 мянган төгрөг;
- Тамирчдын тэмцээнд оролцох замын зардалд 17,758.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь тайлант онд урсгал үйл ажиллагааны төсвөөс 448,062.6 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнээс шууд худалдан авалтын аргаар 42,297.8 мянган төгрөгийн хүнсний материал, 2,562.6 мянган төгрөгийн бичиг хэрэг, 403,202.3 мянган төгрөгийн бусад хангамжийн материалын худалдан авалтыг 53 аж ахуйн нэгж, 7 иргэнтэй хийсэн байна.



## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах урсгал зардал, төрийн хэмнэлт, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитор Т.Отгонцэцэг, аудиторов туслах Д.Мандахбаяр нар гүйцэтгэж, хяналтыг чанарын удирдлагын менежер Ц.Бямбажав, гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав, НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02/28 дугаар албан бичгээр “Өлзийт экаунт аудит” ХХК-д ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,790,033.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 26,850.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэж цалин хөлсийг ажлын гүйцэтгэлээр олгож ажилласан боловч дараах зөрчил байна. Үүнд:

1.Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой ажил гүйлгээг хөөн шалгахад байгууллагын хөрөнгөөр хуулиар зөвшөөрөгдөөгүй 544.3 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авсан байна.



Энэ нь УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.20-д "Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүснэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг санхүүжүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: Хуулиар зөвшөөрөгдөөгүй бараа бүтээгдэхүүн худалдан авсан 544.3 мянган төгрөгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

2.Тайлант онд албан хэрэгцээнд 185,152.6 мянган төгрөгийн барааг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, нэр бүхий 49 аж ахуйн нэгжээс шууд худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ". 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиалгын хүсэлтийг илгээж, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж өгөв.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 448,606.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 4,515,386.2 мянган төгрөгийн 95 мэдээллийг байршуулахаас 4,515,386.2 мянган төгрөгийн 95 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.



#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1.Тайлант хугацаанд 3 байгууллагаас 262,910.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийж харьцуулалт болон нээлттэй тендер зохион байгуулж ажиллаагүй байна. Энэ нь УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.20-д "Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүснэ", ТБОНӨБАҮХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу зохион байгуулаагүй, зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлээ.

2.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлээгүй байна .

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг төлөвлөн баталж, дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээх, гүйцэтгэлийн тайланг цахим системд мэдээлж байх зөвлөмж өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, зардал, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, 2,923,446.31 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгсөн. Үүнд: Худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, НДШ, ХХОАТ-ын тайлан зөрүүтэй, орлого зөрүүтэй тайлагнасан, хөрөнгө орлогод бүртгээгүй зэрэг зөрчлийг гаргасан.

Завсрын аудитаар өгсөн 7 зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.



#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 327,408.4 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт |           | Биелэлт |           |       |
|----------|------------------------|-----------|---------|-----------|-------|
|          | Тоо                    | Дүн       | Тоо     | Дүн       | Хувь  |
| Зөвлөмж  | 3                      | 327,409.4 | 3       | 327,409.4 | 100.0 |
| Нийт дүн | 3                      | 327,409.4 | 3       | 327,409.4 | 100.0 |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь татварын цахим системд татварын баазыг 2 үүсгэснээс татварын авлага, өглөгийн үлдэгдлүүд зөрүүтэй байгааг залруулсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 138,190.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны хуримтлагдсан үр дүн 126,576.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайланд хөрөнгө борлуулсан орлого 370.0 мянган төгрөг, бусад тооцооны дансны гүйлгээ 11,244.0 мянган төгрөг, нийт 11,614.0 мянган төгрөгийг тайлагнаагүй байна.

Аудитаар нийт 10,748.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, зөрчлийг арилгах 5,100.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 5,647.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 10,748.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 16,102.4 мянган төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 5.1 Албан шаардлага

5.1.1 Уралдаан, тэмцээнд оролцсон гадаадын 9 тамирчинд олгосон нийт 28,130.0 мянган төгрөгийн шагналаас 4,219.50 мянган төгрөгийн ХХОАТ-ыг татварыг суутгаагүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



Энэ нь УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.20-д "Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүснэ", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу "Энэ хуулийн 5.5-д заасан Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсад оршин суугч бус этгээдээс татварыг суутган тайлагнаагүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүллээ.

5.1.2 Хувь хүнд олгосон 214,850.0 мянган төгрөгийн спортын, уралдаан тэмцээний шагналаас суутгасан ХХОАТ-ыг 881.0 мянган төгрөгийг татварын албанд дутуу тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг", Татварын Ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг хэлнэ" гэж заасан байгаа тул аж ахуйн нэгж нь суутган төлөгчийн үүргээ биелүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүнээс суутган тооцсон татварыг татварын албанд үнэн зөв тайлагнаж ажиллаагүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүллээ.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Цалин хөлсний тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Нийгмийн даатгалын тайланд ажилтны цалин хөлсийг 1,862.0 мянган төгрөгөөр дутуу, 707.2 төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС 39-5а-Ажилтан нь холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүхэлдээ төлөгдөж барагдахаар хүлээгдэж буй доор дурдсан ажилтны богино хугацааны тэтгэмж: i) Цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл; ii) Ээлжийн амралтын цалин, өвчтэй байх хугацааны тэтгэмж; iii) Ашиг хуваалт ба шагнал урамшуулал; iiiii) Одоо байгаа ажилтнуудад олгодог мөнгөн бус тэтгэмж, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.22-т "Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө" гэж



заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөдөлмөрийн хөлсийг Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд үнэн зөв тайлагнах, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах.

Илрүүлэлт-2: Цалингийн зардлыг ХХОАТ-ын тайлантай тулган шалгахад 3,078.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС 39 Ажилтны тэтгэмж -ын 5-д "Ажилтан нь холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш 12 сарын дотор бүхэлдээ төлөгдөж барагдахаар хүлээгдэж буй тэтгэмжүүд орно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; 27 дугаар зүйлийн 27.1.Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1, 20.4-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй холбогдон гардаг тайлангуудыг үнэн зөв тайлагнаж, зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 31 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга                                     | Нийт алдаа |           | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |           | Буруу тусган илэрхийлсэн |           | Үүнээс     |           |              |     | Зөвлөмж |     |
|-------------------------------------------------------|------------|-----------|-----------------------------------|-----------|--------------------------|-----------|------------|-----------|--------------|-----|---------|-----|
|                                                       |            |           |                                   |           |                          |           | Залруулсан |           | Залруулаагүй |     |         |     |
|                                                       | Тоо        | Дүн       | Тоо                               | Дүн       | Тоо                      | Дүн       | Тоо        | Дүн       | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдэл алдаатай | 1          | 126,576.4 |                                   |           | 1                        | 126,576.4 | 1          | 126,576.4 |              |     |         |     |
| Мөнгөн гүйлгээний тайланд орлого дутуу тусгасан       | 1          | 11,614.00 | 1                                 | 11,614.00 |                          |           | 1          | 11,614.0  |              |     |         |     |
| Дүн                                                   | 2          | 138,190.4 | 1                                 | 11,614.00 | 1                        | 126,576.4 | 2          | 138,190.4 |              |     |         |     |



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                                | Нийт зөрчил |          | Үүнээс        |     |                 |          |         |         |                                      |                     |                                                 |     |
|-------------------------------------------------------------------|-------------|----------|---------------|-----|-----------------|----------|---------|---------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                                                                   |             |          | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |          | Зөвлөмж |         | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                                                   | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн | Тоо             | Дүн      | Тоо     | Дүн     | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| Татварын хуулийн дагуу гадаад иргэдээс татвар суутгаагүй          | 1           | 4,219.5  |               |     | 1               | 4,219.50 |         |         |                                      |                     |                                                 |     |
| Уралдаан тэмцээний шагналаас суутгасан татварыг дутуу тайлагнасан | 1           | 881.0    |               |     | 1               | 881.00   |         |         |                                      |                     |                                                 |     |
| Нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан.                     | 1           | 2,569.2  |               |     |                 |          | 1       | 2,569.2 |                                      |                     |                                                 |     |
| ХХОАТ-ын тайланд цалин хөлсийг дутуу тайлагнасан.                 | 1           | 3,078.5  |               |     |                 |          | 1       | 3,078.5 |                                      |                     |                                                 |     |
| Дүн                                                               | 4           | 10,748.2 |               |     | 2               | 5,100.5  | 2       | 5,647.7 |                                      |                     |                                                 |     |



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга                                                                                                                    | Нийт зөрчил |           | Үүнээс        |       |                 |           |         |           |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------|---------------|-------|-----------------|-----------|---------|-----------|
|                                                                                                                                       |             |           | Төлбөрийн акт |       | Албан шаардлага |           | Зөвлөмж |           |
|                                                                                                                                       | Тоо         | Дүн       | Тоо           | Дүн   | Тоо             | Дүн       | Тоо     | Дүн       |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил                                                                              |             |           |               |       |                 |           |         |           |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлээгүй | 1           | 0         |               |       |                 |           | 1       | 0         |
| Дүн                                                                                                                                   | 1           | 0         |               |       |                 |           | 1       | 0         |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                                                                                              |             |           |               |       |                 |           |         |           |
| Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй                                                                                           | 1           | 262,910.0 |               |       | 1               | 262,910.0 |         |           |
| Байгууллагын хөрөнгөөр хуулиар зөвшөөрөгдөөгүй бараа худалдан авсан.                                                                  | 1           | 544.3     | 1             | 544.3 |                 |           |         |           |
| Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй                                                                                             | 1           | 185,152.6 |               |       |                 |           | 1       | 185,152.6 |
| Дүн                                                                                                                                   | 3           | 448,606.9 | 1             | 544.3 | 1               | 262,910.0 | 1       | 185,152.6 |
| Нийт дүн                                                                                                                              | 4           | 448,606.9 | 1             | 544.3 | 1               | 262,910.0 | 2       | 185,152.6 |





## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 02 дугаар сарын 25

№ 18/1725025

Улаанбаатар хот

НТАГ - 2025/805/НА-СМ - ТМ

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээ, шаардлагагүй 544,350.00 (таван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун тавин) төгрөгийн бараа худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад зардал" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагагүй бараа материалд зарцуулсан 544,350.00 (таван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун тавин) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар4-т ирүүлэхийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга С.Саранцэцэг, нягтлан бодогч С.Ганчимэг нарт хариуцуулав.

### ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ийн  
ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН,  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.ЭРДЭНЭЖАВ

Я.АЛТАНЦЭЦЭГ

1117145633  
УХА0612 9077276

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02051167





НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 78/17225025

Улаанбаатар хот

НТАС- 2025 /805/НА-СМ-Тулз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 262,910,000.00 (хоёр зуун жаран хоёр сая есөн зуун арван мянган) төгрөг шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.", 44 дүгээр зүйлийн 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасантай нийцэхгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам" ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны хууль, журам мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 31-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар 3-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга С.Саранцэцэг, нягтлан бодогч С.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

М.Эрдэнэжав

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ



<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043336





НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 79/17225025

Улаанбаатар хот

НТМС - 2025/805/НА-СТМ-Тшз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүнд олгосон спортын, уралдаан тэмцээний шагналаас суутгасан 881,000.00 (найман зуун наян нэгэн мянган) төгрөгийн ХХОАТ-ыг татварын албанд тайлагнаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-д "урлаг спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр" мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2 "энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.ХХОАТ-ын хуулийн дагуу суутган авч татварын албанд тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар2-т ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга С.Саранцэцэг, нягтлан бодогч С.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ







НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 80/17225025

Улаанбаатар хот

Итгэс - 2025/805/НА-СТП - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уралдаан, тэмцээнд оролцсон гадаадын тамирчинд олгосон шагналаас 4,219,500.00 (дөрвөн сая хоёр зуун арван есөн мянга таван зуун) төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу "Энэ хуулийн 5.5-д заасан Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Уралдаан, тэмцээнд оролцсон гадаад иргэдээс татвар суутгаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар1-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга С.Саранцэцэг, нягтлан бодогч С.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

 Ч.ЭРДЭНЭЖАВ

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР



 Я.АЛТАНЦЭЦЭГ

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043332